



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А194

Хажуу шинэ ус

**Хөрөнгийн үнэлгээний ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Хоршооны тухай хуулийн 42.1.9 дэх заалт Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалын хавсралтын 3.4.4 дахь заалт мөн сайдын 2022 оны А/243 тоот тушаалын хавсралтын 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хоршоог хөгжүүлэх сан"-гийн зээлд барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Өлзийтогтох (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Н.Ганбат (Санхүү албаны дарга)

Д.Сарангэрэл (Хүнс, жижиг дунд хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Алтансаргай (Татварын улсын байцаагч)

Г.Булган (Нийгмийн даатгалын байцаагч)

2.Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж захиалагчин хүсэлтийн дагуу холбогдох материалыг үндэслэн орон нутгийн зах зээлийн ханштай уялдуулан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг бодитой тогтоож зээлдэгч тус бүрээр тайланг ирүүлэхийг ажлын хэсгийн дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА



ТАРИУНАА

482301199